

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

*“Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд*

### Аудиторын дүгнэлт

Бид “Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК (цаашид “Компани” гэх)–ийн 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АОУС–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг

**У. Нарандэлгэр**  
Аудитор



Баталсан

**Э. Булган**  
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот  
2024 оны 3 дугаар сарын 12-ны өдөр

**Нексия Глобал Монголиа Аудит ХХК**  
Нексия Интернэйшнл-ийн албан ёсны гишүүн

Вэб: [www.nexia.com](http://www.nexia.com)

## ХАРААТ БУС АУДИТОРЫН НЭМЭЛТ ТАЙЛАН

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Бид Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн хүрээнд компанид мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд дараах догол мөрөнд тусгагдсан асуудлаас бусад зүйлсийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журмуудыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК нь Нэгж эрх эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 23/07 тогтоолоор сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэн баталсан. Аудитын гүйцэтгэлийн явцад хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэлтийг тайлангийн хугацааны эцсийн байдлаар уг бодлогод заасан хязгаар, шаардлагад нийцсэн эсэхийг тестлэн шалгахад Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогод заасан дараах шаардлагууд хангагдахгүй байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн нэг салбарт оруулах хөрөнгө оруулалт нийт багцын 25 хувь хүртэл байхаар заасан ч хөрөнгө оруулалтын багцын 41.5 хувийг санхүүгийн үйлчилгээний салбарт байршуулсан;

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг удирдахдаа Хөрөнгө оруулалтын бодлогод заасан хязгаар, шаардлагыг зөрчсөн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргасан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-д "Хөрөнгө оруулалт хийх хязгаар, хориглох зүйлийг хөрөнгө оруулалтын бодлогод урьдчилан тодорхойлж, түүнийг чанд мөрдөж ажиллах, ..." гэж заасантай нийцэхгүй байна.

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг

  
**У. Нарандэлгэр**  
Аудитор



Баталсан

  
**Э. Булган**  
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот  
2024 оны 3 дугаар сарын 12-ны өдөр

2023 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Тод</b>	<b>2023</b>	<b>2022</b>
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүний орлого	15	109,336	75,312
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	15	17,299	45,567
Ногдол ашгийн орлого	15	65,685	105,978
Бусад орлого		638	
Үнэт цаасны арилжааны олз	15	75,390	
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бусад цэвэр өөрчлөлт	15	(799,682)	(2,640,240)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн цэвэр олз	16	(1,914)	199,915
<b>Нийт орлого/ (Зардал)</b>		<b>(533,248)</b>	<b>(2,213,468)</b>
ХОМК-ийн үйлчилгээний зардал	17	(154,601)	(177,380)
Кастодианы үйлчилгээний зардал	17	(21,628)	(24,756)
Бусад зардал	17	(61,223)	(127,037)
<b>Нийт үйл ажиллагааны зардал</b>		<b>(237,452)</b>	<b>(329,173)</b>
<b>Татварын өмнөх ашиг/ (алдагдал)</b>		<b>(770,700)</b>	<b>(2,542,641)</b>
Орлогын албан татварын зардал	18	(22,318)	267,935
<b>Тайлант жилийн ашиг/ (алдагдал)</b>		<b>(793,018)</b>	<b>(2,274,706)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>11</b>	<b>Төгрөг (15.86)</b>	<b>Төгрөг (45.49)</b>

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Тод</b>	<b>2023-12-31</b>	<b>2022-12-31</b>
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Бусад авлага	8	7,346	18,681
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	9	5,656,944	6,651,047
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	9	175,000	371,881
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10	549,749	276,072
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>6,389,039</b>	<b>7,317,681</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Хойшлогдсон татварын хөрөнгө	13	12,806	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>12,806</b>	<b>-</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>6,401,845</b>	<b>7,317,681</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Бусад өглөг	12	14,050	44,798
Орлогын татварын өглөг		12,372	7,235
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>		<b>26,422</b>	<b>52,033</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өглөг	13	-	214,649
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>		<b>-</b>	<b>214,649</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>26,422</b>	<b>266,682</b>
<b>Цэвэр хөрөнгө</b>			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	11	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг	11	1,375,423	2,050,999
<b>Нийт цэвэр хөрөнгө</b>		<b>6,375,423</b>	<b>7,050,999</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b>		<b>6,401,845</b>	<b>7,317,681</b>

2023 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Мянган төгрөгөөр	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
<b>2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000</b>	<b>4,325,705</b>	<b>9,325,705</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>5,000,000</b>	<b>4,325,705</b>	<b>9,325,705</b>
Тайлант жилийн ашиг, алдагдал	-	(2,274,706)	(2,274,706)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант жилд гаргасан нэгж эрх	-	-	-
Буцаан татсан нэгж эрх	-	-	-
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000</b>	<b>2,050,999</b>	<b>7,050,999</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	232,626	232,626
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>5,000,000</b>	<b>2,283,625</b>	<b>7,283,625</b>
Тайлант жилийн ашиг, алдагдал	-	(793,018)	(793,018)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	(115,184)	(115,184)
Тайлант жилд гаргасан нэгж эрх	-	-	-
Буцаан татсан нэгж эрх	-	-	-
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000</b>	<b>1,375,423</b>	<b>6,375,423</b>

2023 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Тод</b>	<b>2023</b>	<b>2022</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Тайлант жилийн ашиг/(алдагдал)</b>		<b>(793,018)</b>	<b>(2,274,706)</b>
Тохируулга:			
Нийт хүүгийн орлого		(126,635)	(120,879)
Ногдол ашгийн орлого		(65,685)	(105,978)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй олз		1,914	(199,915)
Орлогын албан татварын зардал		22,318	(267,935)
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг/(алдагдал)</b>		<b>(961,106)</b>	<b>(2,969,413)</b>
Бусад авлагын өсөлт/бууралт		11,335	(18,681)
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бууралт		196,881	409,692
Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн өсөлт/ бууралт		994,103	2,383,310
Хойшлогдсон татварын өрийн өсөлт бууралт		(5,648)	
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/бууралт		(24,205)	19,752
<b>Үндсэн үйл ажиллагааны зарцуулсан мөнгө</b>		<b>211,360</b>	<b>(175,340)</b>
Хүлээн авсан ногдол ашиг		62,331	95,437
Хүлээн авсан хүү		113,358	100,647
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>387,049</b>	<b>20,744</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Гаргасан нэгж эрх		-	-
Олгосон ногдол ашиг		(109,434)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(109,434)</b>	<b>-</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз		(3,938)	4,085
<b>Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>273,677</b>	<b>24,829</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>276,072</b>	<b>251,243</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>549,749</b>	<b>276,072</b>